



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 771

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2022 оны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 119,894,171.00 (нэг зуун арван есөн сая найман зуун ерэн дөрвөн мянга нэг зуун далан нэг) төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал түүнийг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэлд дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай.

2.1.Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.1 дэх заалтыг тус тус мөрдөж ажиллах, батлагдсан хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахыг таслан зогсоох;

2.2.Тус яамны санхүүгийн тайланд бүртгэлгүй 12 байршил дахь 524.6 га газрыг Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу санхүүгийн тайлагналын зориулалтаар үнэлж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохих зөвшөөрлийг авч, данс бүртгэлд бүртгэх;

2.3.Төрийн эзэмшлийн газар дээр байрлах зөвшөөрөлгүй хоёр ширхэг барилгыг (Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшил газарт байрлах) нүүлгэн шилжүүлэх, төрийн эзэмшил газрыг чөлөөлүүлэх арга хэмжээ авч ажиллах;

2.4.Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн газрын авто зам, зогсоолын талбайд төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэгчийг зохих хууль тогтоомжийн хүрээнд дахин сонгон шалгаруулах;

2.5.Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор

123007290

36-r huraldaan.docx

баталсан “Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдлөг болгон ажиллах;

2.6.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдал”-д дотоод аудит санхүүгийн хяналт шалгалтыг хийх гэж заасныг баримтлан ажиллах;

3.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-г даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 1-ийн өдрийн
2023 оны 12 дугаар тогтоолын хавсралт



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМАНД ХИЙСЭН
ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫГ АРИЛГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (сая.төг)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс гадуур бэлтгэсэн үндсэн хөрөнгө.	119.8	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус мөрдөж ажиллах.
2	Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн эзэмшил газар дээр байрлах эзэмшигч нь тодорхойгүй хоёр ширхэг барилгыг төрийн эзэмшлийн газраас нүүлгэн шилжүүлэх	0	Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 10 дугаар тогтоолын 7-д заасны дагуу хууль, хяналтын байгууллагатай хамтран холбогдох арга хэмжээг авч ажиллах.
3	Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн газрын авто зам, зогсоолын талбайд төлбөртэй зогсоолын үйлчилгээ эрхлэгчийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд сонгон шалгаруулаагүй	0	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно” гэж заасантай нийцэхгүй байна. Мөн Авлигын эсрэг хуулийн 3.1.4-д давуу байдал гэж “Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласнаар хувь хүн, хуулийн этгээдэд буй болох эдийн болон эдийн бус ашигтай байдлыг” ойлгоно гэж заасан байх тул, тус зогсоолын сонгон шалгаруулалтыг хийхдээ Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 51 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах.
Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн дүн		119,894,171.00 (нэг зуун арван есөн сая найман зуун ерэн дөрвөн мянга нэг зуун далан нэг)	